УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧ ЗЭРЭГ ТУСГАЙ СУБЪЕКТИЙН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХАРЬЯАЛЛЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/218

2024.10.15

Захиалсан:	УИХ-ЫН ГИШҮҮН Г.ХОСБАЯР
Хянасан:	Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь
Судалгаа удирдсан:	ПСХХ-ийн хэлтсийн дарга П.Түмэнцэцэг
Судлаачид:	Э.Дашзэгвэ, И.Жаргалзаяабямба, Б.Ууганжаргал

Улаанбаатар
2024 он

Агуулга

УДИРТГАЛ 3
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ....4
НЭГ. МОНГОЛ УЛСАД ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧ ЗЭРЭГ ТУСГАЙ СУБЪЕКТИЙН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХАРЬЯАЛЛЫН ТАЛААР 7
1.1. Монгол Улсын Мөрдөн байцаах албаны түүхэн тойм 7
1.2. Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэм хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяалал, одоогийн нөхцөл байдал 10
ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА 12
2.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС 12
2.2. БҮГД НАЙРАМДАХ АРМЕНИ УЛС 18
2.3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС 23
АШИГЛАСАН ЭХ МАТЕРИАЛ....27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ТСҮГХМХ	Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс
ӨАТАХМША	Өндөр албан тушаалтны авлигын хэргийг мөрдөн шалгах алба

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын захиалгын дагуу “Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяаллын талаарх харьцуулсан судалгаа”-г Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, тэдгээрийн харьяаллын талаар Монгол Улсын болон гадаадын зарим орны эрх зүйн орчин, туршлагыг хууль тогтоомж, практик үйл ажиллагааны хүрээнд тоймлон судлах.

Мэдээлэл лавлагааны хамрах хүрээ: Асуудлыг Монгол Улсын болон гадаадын зарим орны эрх зүйн орчны хүрээ, холбогдох хууль тогтоомж, практик үйл ажиллагааны туршлага болон олон улсын байгууллага, судалгааны төв, судлаач, эрдэмтдийн гаргасан гарын авлага, зөвлөмж болон эрдэм шинжилгээний өгүүлэл, материалын хүрээнд тус тус харьцуулан судаллаа.

Мэдээлэл лавлагааны бүтэц: Судалгааны тайлан үндсэн 2 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт, Монгол Улс дахь Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, тэдгээрийн харьяаллын талаарх мэдээлэл, Хоёрдугаар хэсэгт, Хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үйлдэн гэмт хэргийн мөрдөн шалгах эрх бүхий байгууллага, тэдгээрийн эрх хэмжээ, томилгооны талаарх гадаадын зарим орны туршлага, эрх зүйн орчны талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

Түлхүүр үг: *Мөрдөн байцаах алба, Тусгай субъект, Хууль сахиулагч, хэргийн харьяалал*

Key words: *Investigation department, special subject, law enforcement officer, criminal jurisdiction*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монгол Улсад Мөрдөн байцаах алба үүсэж хөгжсөн цаг үеэсээ эхлэн харьяаллын хувьд Прокурорын байгууллага, Цагдаагийн байгууллагын хооронд хэд хэдэн удаа шилжиж байжээ. Үүнтэй адилаар шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах харьяалал, эрхлэх байгууллага ч мөнхүү хэд хэдэн удаа солигдсон байдаг. Тухайлбал, 2002 онд Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдаж, тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан. Гэтэл 2014 онд тус Мөрдөн байцаах албыг татан буулгаж, тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн албан тушаал, авлигын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байсан харьяалал нь Авлигатай тэмцэх газарт шилжжээ.

Одоогийн байдлаар Монгол Улсад шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг дараах 2 байгууллага харьяалан мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Авлигатай тэмцэх газар;
- Цагдаагийн Ерөнхий газрын харьяа Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс (ТСҮГХМХ).

Авлигатай тэмцэх газар шүүгч, прокурор, цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагчдын авлига, албан тушаалын гэмт хэрэг болон цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагчийн үндэслэлгүй хорьж, мөрдсөн, эрүүдэн шүүсэн үйлдэлтэй холбоотой гэмт хэргийг харьяалан шийдвэрлэж байна.

Харин Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс Авлигатай тэмцэх газрын албан хаагч болон шүүгч, прокурор, цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагчийн үйлдсэн бусад хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Дээрх хоёр байгууллагын холбогдох мөрдөн шалгах ажиллагаа аль аль прокурорын байгууллагын хяналтад явагдана. Түүнчлэн гэмт хэргийн гомдол, мэдээлэл, гэмт хэргийн ерөнхий харьяаллыг Улсын ерөнхий прокурорын тушаалаар тогтоодог.

Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилдог бол Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн даргыг Цагдаагийн Ерөнхий газрын дарга томилж, чөлөөлдөг байна. Харин Цагдаагийн ерөнхий газрын

даргыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлдөг байна.

АНУ, Армени, БНСУ зэрэг дэлхийн зарим улс орнуудын тухайд, шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг хууль сахиулах байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны онцлог нь дараах байдалтай байна. Үүнд:

АНУ-д шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий хэд хэдэн байгууллага, албан тушаалтнууд байдаг. Тэдгээрээс Хууль зүйн яам (Department of Justic)[1]ны дэргэдэх Ерөнхий байцаагчийн албаны Мөрдөн шалгах хэлтэс (Investigations Division of Office of the Inspector General)[2] голлох үүрэг гүйцэтгэдэг. Тус алба нь цагдаагийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын ажилтнууд, шүүгч, прокурор болон холбооны, мужийн, орон нутгийн хууль сахиулах байгууллагын албан хаагчдад холбогдох хүч хэрэглэсэн, эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэн ашигласан, хилсээр баривчилсан, шүүгдэж буй этгээдэд бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулсан, санаатайгаар эмнэлгийн тусламж үзүүлэхээс зайлсхийсэн, бэлгийн дарамт үзүүлсэн, гэмт хэргийг таслан зогсоохоос зайлсхийсэн зэрэг гэмт хэргүүдийг мөрдөн шалгадаг.

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой гэмт хэргийн мэдээллийг Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурорын томилсон Тусгай төлөөлөгч (Special Agent) шалгаж, мөрдлөг явуулдаг байна. АНУ-д Ерөнхий атторней буюу Ерөнхий прокурор нь нэгэн зэрэг Хууль зүйн асуудал хариуцсан сайдын алба хашдаг онцлогтой[3].

Бүгд Найрамдах Армени Улсад Мөрдөн шалгах тусгай албаны Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг, албан тушаалтны гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Corruption, Organized and Official Crimes*), Эрүүдэн шүүх болон хүний эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (Department of Investigation of Tortures and Crimes against Person), Нийтлэг шинжтэй гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (Department of Investigation of Crimes of General Character)-үүд нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдах албан тушаалтан болон төрийн тусгай албаны ажилтан албан тушаалаа урвуулан ашиглах, эсхүл биеэр үйлдсэн гэмт хэрэг, мөн сонгуулийн үйл явцтай холбоотой эрүүгийн гэмт хэргийг урьдчилан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг байна.

[1] https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct
[2] https://oig.justice.gov/about
[3] Б. Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан “Прокурорын хяналт”,2009,УБ

Тусгай мөрдөн байцаах албаны даргыг тус улсын Ерөнхий прокурорын санал болгосноор Бүгд Найрамдах Армени Улсын Ерөнхийлөгч уг албан тушаалд томилдог байна. Мөрдөн шалгах тусгай албаны ажилтны эсрэг эрүүгийн хэрэг үүсгэн шалгах эрүүгийн хэргийн харьяаллыг Армени Улсын Ерөнхий прокурор тогтоодог.

БНСУ-д шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийн мөрдөн шалгах эрх бүхий 2 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээр нь:

- Дээд прокурорын газрын харьяа Мөрдөн байцаах алба;
- Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах алба (Corruption Investigation Office for High-ranking Officials, ӨАТАХМША) юм.

Дээд прокурорын газрын харьяа Мөрдөн байцаах алба нь Ерөнхий прокурорт шууд харьяалагдах, босоо удирдлагын тогтолцоотой бөгөөд Прокурорын мөрдөн байцаах ажиллагааг явуулдаг бөгөөд олон нийтийн анхааралд орсон томоохон авлига, албан тушаалын хэрэг, улсын аюулгүй байдал, батлан хамгаалах болон санхүүгийн зах зээлтэй холбоотой томоохон хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.

Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах алба нь 2021 онд байгуулагдсан, авлигын хэргийг мөрдөн шалгах, өндөр албан тушаалтнуудын гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой бие даасан, хараат бус, тусгай байгууллага юм[4]. Албаны дарга (Director General)-ыг Ерөнхийлөгч тодорхой нөхцөл, журмын хүрээнд шууд томилдог. Тус алба бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч албан тушаалтныг мөрдөн шалгах бие даасан эрхтэй. Үүнд: Бүх төрлийн авлигын хэргүүд болон шүүх, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын гэмт хэргүүд багтдаг байна. Ингэхдээ прокурорын байгууллагын хяналтаас тусдаа бие даан гэмт хэргийг мөрдөх эрхтэй байдаг ажээ. Энэхүү бүтэц, зохион байгуулалт нь БНСУ-ын хууль сахиулах тогтолцоонд прокурорын байгууллагын хэт төвлөрсөн эрх мэдлийг саармагжуулах, шинэ төвийг сахисан хяналтын байгууллагыг бий болгож, авлигын эсрэг хяналтыг сайжруулах зорилготой байна.

[4] https://cio.go.kr/eng/content/243

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

НЭГ. МОНГОЛ УЛСАД ШҮҮГЧ, ПРОКУРОР, МӨРДӨГЧ ЗЭРЭГ ТУСГАЙ СУБЪЕКТИЙН ҮЙЛДСЭН ГЭМТ ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХАРЬЯАЛЛЫН ТАЛААР

1.1. Монгол Улсын Мөрдөн байцаах албаны түүхэн тойм

Улсын цагдан сэргийлэх газрын даргын 1940 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 41 дугаар тушаалд “Цагдан сэргийлэх газар бол гэмт хэрэг үйлдэгчдийг дайчлан баривчлах, хорьж мөрдөх зэргээр байцаан нягтлах ажлыг явуулах, мөрдөн байцаах газар” хэмээн дурдаж мөрдөх албаны үйл ажиллагааны эрх зүйн үндсийг анх тодорхойлсон байдаг. Улмаар Дотоод явдлын яам (ДЯЯ)-ны 1946 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 504 тоот тушаалаар Улсын Цагдан Сэргийлэх газрын гүйцэтгэх 1 дүгээр хэлтсийн харьяанд Мөрдөн байцаах группийг 10 алба хаагчтай байгуулснаар Мөрдөн байцаах албаны үндэс суурь тавигдаж өдгөө 77 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна.

Анх байгуулагдсанаас хойш цаг үеийн нөхцөл байдал, эрх зүйн орчны өөрчлөлттэй уялдуулан тус албаны бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, өргөжиж, мөн нэршил өөрчлөгдөн хүний нөөцийн хувьд бэхжиж одоогийн алба болж төлөвштөлөө дараах байдлаар хөгжин ирсэн. Сүүлийн үеийн онцлог өөрчлөлтүүдээс дурдвал:

- БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1962 оны 144 дүгээр зарлиг, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн мөн оны 313 дугаар тогтоолоор Цагдан сэргийлэх ерөнхий газрын системд ажиллаж байсан Мөрдөн байцаах аппаратыг татан буулгаж, 1962 оны 07 дугаар сарын 01-нээс Прокурорын байгууллагад мөрдөн байцаах албыг төвлөрүүлэн, Улаанбаатар хотын прокурорын газарт Мөрдөн байцаах газар, аймгийн прокурорын газарт Мөрдөн байцаах группийг ажиллуулахаар шийдвэрлэж байжээ;
- Түүнээс 2 жилийн дараа мөрдөн байцаах ажлын удирдлага зохион байгуулалт оновчтой биш, хэргийн илрүүлэлт хангалтгүй шалтгаанаар МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны 1964 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 218 дугаар тогтоолоор мөрдөн байцаах ажлыг буцаан Цагдан сэргийлэх байгууллагад шилжүүлж, Нийгмийг аюулаас хамгаалах яам (НАХЯ)-ны сайдын 1964 оны 511 дугаар тушаалаар Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын харьяа Мөрдөн байцаах газрыг байгуулсан байдаг;

- Мөрдөн байцаах албаны бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох тухай Улсын Бага Хурлын тогтоолын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газрын 1992 оны 101 дүгээр тогтоолоор УАБХЕГ-ын Мөрдөн байцаах алба, Прокурорын байгууллагын мөрдөн байцаах албадын орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт ЦЕГ-т шилжүүлж Улсын мөрдөн байцаах газрыг байгуулжээ;
- Эрх зүйн тогтолцооны шинэчлэл, нийгмийн харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор “Прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2002 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 47 дугаар тогтоол батлагдсантай холбоотойгоор Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 179 дүгээр тогтоолын дагуу Мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагчдын орон тоо, төсөв, эд хөрөнгийн хамт цагдаагийн байгууллагаас Улсын ерөнхий прокурорын мэдэлд шилжүүлсэн. Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Мөрдөн байцаах алба байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн;
- Авлигын эсрэг хуулийн дагуу Монгол Улсад анх удаа авлигатай тэмцэх тусгай байгууллага-Авлигатай тэмцэх газар байгуулагдан 2007 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор 2007 онд тус албаны Албан тушаалын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийг татан буулгасан;
- Тухайн үеийн хадгаламж зээлийн хоршоодын хууль бус үйл ажиллагааг мөрдөн шалгах Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтсийг тус газарт Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтэс болгон бүтэц, зохион байгуулалтыг өөрчилсөн. 2014 онд Цагдаагийн албаны хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 95 дугаар тушаалаар Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газар байгуулагдан тодорхой төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, дэмжлэг үзүүлэх үүрэгтэйгээр ажиллаж байсан;
- Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны Б/251 дугаар тушаалаар Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн газрыг татан буулгаж Мөрдөн байцаах газрыг дахин байгуулж, тус газрын бүтцэд мөн даргын 2016 оны Б/196 тушаалаар Эрүүгийн цагдаагийн газрын Эрэн сурвалжлах хэлтсийг нэгтгэснээр 8 хэлтэс 3 тасаг 4 хэсэгтэйгээр;
- Монгол Улсын Их Хурлын 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай мөн өдрийн хуулиар прокурорын байгууллагын тухай хуулийн 10 дугаар зүйл /Улсын прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба, 45 дугаар зүйл мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч/-ийг тус тус хүчингүй болсноор Прокурорын байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах алба татан буугдаж, тагнуул, цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор,

шүүгчийн үйлдсэн албан тушаал, авлигын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байсан харьяалал нь Авлигатай тэмцэх газарт шилжжээ.

Бүтэц, зохион байгуулалтын хувьд 2017 онд Цагдаагийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг шинэчлэн баталсантай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/133 дугаар тушаалаар Мөрдөн байцаах албаны болгон өргөжүүлж мөрдөн шалгах чиг үүргийн газар 1, хэлтэс-7, хэсэг-1, дэмжлэг үзүүлэх хэлтэс 2, тасаг-1 гэсэн бүтэцтэйгээр, мөн даргын 2018 оны А/11 дүгээр тушаалаар Хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх газрыг татан буулгаж, дэмжлэг үзүүлэх хэлтэс 1, мөрдөн шалгах чиг үүргийн хэлтэс-6, тасаг-1, хэсэг-1 бүтэцтэйгээр зохион байгуулж байсан. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/214 дугаар тушаалаар Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэс, мөн даргын 2020 оны А/319 дугаартай тушаалаар Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс, мөн даргын 2022 оны А/206 дугаар тушаалаар цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах дагнасан чиг үүрэгтэй Кибер гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийг тус албаны бүтцэд шинээр байгуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/306 тоот тушаалаар мөнхүү албаны Кибер гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийг татан буулгаж бүтэц орон тоогоор нь Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газарт шилжүүлж одоо тус алба нь төвдөө нийт 8 хэлтэс, 1 тасаг, 1 хэсгийн бүтэцтэй, нийслэлийн дүүрэг, орон нутгийн 54 нэгжтэйгээр улсын хэмжээнд хуулиар харьяалуулсан хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Мөрдөн шалгах эрх бүхий алба, албан тушаалтнууд нь 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121, 125 дугаар зүйлд зааснаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах байгууллагад цагдаагийн байгууллага, Тагнуулын ерөнхий газар, цэргийн хэрэг бүртгэх алба, хорих ял эдлүүлэх байгууллагын дарга, гүйцэтгэх ажилтан, хил хамгаалах байгууллагын хэрэг бүртгэх алба, гаалийн байгууллагын хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан, улсын татварын байгууллагын хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан, хөлөг онгоцны ахмад, гал түймэртэй тэмцэх байгууллага, хилийн тагнуулын алба хамаарч байв. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26, 27 дугаар зүйлд зааснаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаалт явуулах байгууллагад Улсын ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албаны, Авлигатай тэмцэх газар, цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллагын мөрдөн байцаагч хамаарч байв. 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд зааснаар тагнуулын байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллага нь хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад хамаарч байна.[5]

[5] Мөрдөх албаны талаарх харьцуулсан судалгаа, ННФ, 2021

1.2. Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэм хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяалал, одоогийн нөхцөл байдал

Эрүүгийн эрх зүйн ерөнхий онолд гэмт хэргийн ерөнхий субъектын зэрэгцээ тусгай субъектын тухай ойлголтыг авч үздэг. Тусгай субъект гэдэг нь ерөнхий субъектэд тавигддаг насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай зэрэг нийтлэг шинжүүдээс гадна нэмэгдэл бусад шинжүүдийг шаардаж байдгаараа онцлогтой. Эрүүгийн хуулийн тусгай ангийн зарим бүлэг болон зүйлд гүйцэтгэгч нь заавал тусгай субъект байх цөөнгүй гэмт хэргийг тогтоосон байдаг. Тэдгээрийн нэг нь энэхүү судалгаанд авч үзэж буй шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг эрхэлж буй ажил, албан тушаалын шинжээр тодорхойлогдох тусгай субъектүүдийн асуудал юм.[6]

Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 05 дугаар сарын 08-ны А/73 дугаар тушаалаар гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоосон. Тус тушаалын хавсралтаар Авлигатай тэмцэх, Тагнуул болон Цагдаагийн дагнасан чиг үүрэх бүхий алба, нэгжээс шалгах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийн харьяаллыг тогтоосон бөгөөд ингэхдээ шүүгч, прокурор, мөрдөгч, төрийн өндөр албан тушаалтан зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын харьяаллыг дараах байдлаар тус тус хуваарилсан байна. Үүнд:

Авлигатай тэмцэх газарт:

- Аймагт үйлдэгдсэн улс төрд нөлөө бүхий этгээд, шүүгч, прокурор, Цагдаа болон Тагнуулын байгууллагын удирдах албан тушаалтан, Засгийн газраас томилогддог төрийн болон холимог, нийтийн өмчит хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, гадаад улсын төрийн болон олон улсын байгууллагын албан тушаалтнуудад холбогдох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар харьяалуулсан гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг;
- Цагдаагийн байгууллагын алба хаагчийн үйлдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйлд заасан “Хууль бусаар баривчлах, саатуулах”, 13.12 дугаар зүйлд заасан “Хууль бусаар мөрдөж мөшгөх”, 21.9 дүгээр зүйлд заасан “Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах” гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг;
- Цагдаа, Тагнуулын байгууллагын алба хаагчийн үйлдсэн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг.

Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэст:

[6] Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги: Гэмт хэргийн бүтэц, Т.Золбоо, 2018 он

- Авлигатай тэмцэх байгууллагын алба хаагчийн үйлдсэн бусад байгууллагад харьяалуулснаас бусад гэмт хэргийн талаах гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг;
- Тагнуулын байгууллагын алба хаагчийн үйлдсэн үйлдсэн бусад байгууллагад харьяалуулснаас бусад гэмт хэргийн талаах гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг;
- Шүүгч, прокурорын үйлдсэн бусад байгууллагад харьяалуулснаас бусад гэмт хэргийн талаах гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг;
- Цагдаагийн байгууллагын алба хаагчийн үйлдсэн бусад байгууллагад харьяалуулснаас бусад гэмт хэргийн талаах гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг;
- Төрийн өндөр албан тушаалтанд холбогдох Авлигатай тэмцэх газар, Тагнуулын байгууллага, Эрүүгийн цагдаагийн алба, Экологийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба болон Хар тамхитай тэмцэх газарт харьяалуулснаас бусад гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг тус тус харьяалуулсан байна.

Шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдлыг харвал:

- АТГ-ын 2023 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар тус онд АТГ-т төрийн тусгай албан хаагчид холбогдох 729 гомдол, мэдээллийн хянан шийдвэрлэсэн байна. Эдгээрээс 206 албан хаагчид холбогдох эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, холбогдох эрх бүхий байгууллагуудад шилжүүлжээ. Энэ нь урьд оноос. 21 хувь өссөн үзүүлэлттэй байна[7];
- Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны статистик мэдээллээс харахад Мөрдөн байцаах албаны ТСҮГХМХ 2022 онд 78, 2023 онд 40 албан хаагчид холбогдох эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байна[8].

Дээрх байгууллагуудын даргын томилгооны хувьд, Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилдог бол Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн даргыг Цагдаагийн Ерөнхий газрын дарга томилж, чөлөөлдөг байна.

[7] https://cdn.greensoft.mn/uploads/users/3172/files/ATG%20tailan-24_01_03.pdf
[8] https://police.gov.mn/resource/information/File/2024/01/09/n5s1moym427bp5fn/Сайт%20сэжигтэн.pdf

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

2.1. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг хууль сахиулах байгууллагын албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий хэд хэдэн байгууллага, албан тушаалтнууд байдаг. Тэдгээр нь эрх хэмжээ, эрх мэдлийн түвшин, цар хүрээ зэргээсээ хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал:

- Хэрэв Холбооны түвшний шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг албан тушаалтнуудтай холбоотой авлига, эрх мэдлээ урвуулан ашиглах болон бусад гэмт хэргийг мөрдөн шалгахад Холбооны мөрдөх товчоо (FBI) голлох үүрэгтэй оролцдог;

- Прокурор зэрэг хууль сахиулах албан тушаалтнуудын үйлдсэн хууль бус үйл ажиллагааг АНУ-ын Хууль зүйн яамны Мөрдөн шалгах хэлтэс шалгадаг;

- Зарим онцгой тохиолдолд, гэмт хэргийн шинж чанарын хувьд болон улс төрийн хувьд ээдрээ төвөгтэй хэргийг шалгахад тусгай прокурор томилогдож болно. Энэ нь гол төлөв хууль зүйн болон зүй ёсны зөрчилд өртсөн байж болзошгүй албан тушаалтнуудыг мөрдөн шалгахад ашиглагддаг;

- Мөн тухайн албан тушаалтан мужийн түвшний хууль сахиулагч байвал тухайн мужийн мөрдөн шалгах байгууллагууд болон дотоодын тусгай албад хариуцан шалгана;

- Түүнчлэн зарим тохиолдолд, шүүгч, прокурорын зүгээс эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах болон бусад хууль зөрчсөн үйлдлүүдийг мөрдөн шалгах зорилгоор тусгай хяналтын зөвлөлүүд байгуулагддаг байна.

Эдгээрээс хууль сахиулах байгууллагын албан хаагчид, ялангуяа прокуроруудтай холбоотой гэмт хэргийг Хууль зүйн яам (Department of Justice)[9]-ны дэргэдэх Ерөнхий байцаагчийн албаны Мөрдөн шалгах хэлтэс (Investigations Division of Office of the Inspector General)[10] хэрхэн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг талаар дэлгэрэнгүй өгүүлье.


Уг алба нь цагдаагийн албан хаагчид, засан хүмүүжүүлэх газрын ажилтнууд, шүүгч, прокурор болон холбооны, мужийн, орон нутгийн хууль сахиулах байгууллагын албан хаагчдад холбогдох хүч хэрэглэсэн, эрх мэдэл, албан тушаалаа хэтрүүлэн

[9] https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct
[10] https://oig.justice.gov/about

ашигласан, хилсээр баривчилсан, шүүгдэж буй этгээдэд бие махбодын болон сэтгэл санааны хохирол учруулсан, санаатайгаар эмнэлгийн тусламж үзүүлэхээс зайлсхийсэн, бэлгийн дарамт үзүүлсэн, гэмт хэргийг таслан зогсоохоос зайлсхийсэн зэрэг гэмт хэргүүдийг мөрдөн шалгадаг.

Түүнчлэн гэмт хэргийг илрүүлэх явцад саад хийсэн, хохирогч болон гэрчийг мэдүүлэг өгөхөд саад учруулсан, мэдүүлгийг хуурамчаар үйлдсэн, хэргийг нуун дарагдуулсан, баримт нотолгоог хуурамчаар үйлдсэн зэрэг хэргүүдийг мөрдөж ял оноодог.[11]

Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд болон төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой гэмт хэргийн мэдээллийг Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурорын томилсон Тусгай төлөөлөгч (Special Agent) шалгаж, мөрдлөг явуулдаг байна.



[11] https://www.law.cornell.edu/uscode/text/18/242

АНУ-д Ерөнхий атторней буюу Ерөнхий прокурор нь нэгэн зэрэг Хууль зүйн асуудал хариуцсан сайдын алба хашдаг онцлогтой[12]. Холбооны улсын эрх зүйн актуудын код (Code of Federal regulations)-д заасны дагуу Тусгай төлөөлөгч нь өөрт олгосон эрхийн хүрээнд АНУ-ын аль ч прокурорын адил мөрдлөг явуулах, ял оноох эрхтэй. Мөн тухайн хэргийн мөрдөлт аль шатанд явж байгаа зэрэг хэрэгт холбоотой мэдээллийг Ерөнхий прокурор болон Хууль зүйн яамны ажилтнуудад мэдээлэх эсэхээ өөрөө шийдэх бүрэн эрхтэй байна.

Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу мөрдлөгийн явцад бий болсон гэнэтийн үйл явдлын талаар Ерөнхий прокурорт мэдээлэх үүрэгтэй. Мөрдөн шалгах үйл явц дууссаны дараа гэмт этгээдэд ногдуулсан ял, эсхүл гэм буруугүйг нотолсон нотолгоог Ерөнхий прокурорт танилцуулна. Ерөнхий прокурор тусгай төлөөлөгчийн мөрдсөн болон ял ногдуулсан аливаа хэргийг Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу олон нийтэд мэдээлэх эсэхийг шийдвэрлэнэ.

Үндсэн хууль, хуулиар баталгаажуулсан аливаа эрх, давуу эрх, халдашгүй дархан байдлаа хасуулах, эсхүл эсрэг гаргасан аливаа ажиллагаанаас бусад тохиолдолд хууль, эрх зүйн болон бусад зохих журмыг өөрт давуу байдлаар ашиглан эрх мэдлээ урвуулан ашиглаж, иргэн болон хуулийн этгээдийг хохироосон бол түүний өмнө хуулийн хариуцлага хүлээнэ.

Шүүхийн албан тушаалтны шүүх эрх мэдлийн хүрээнд хийсэн үйлдэл, эс үйлдэхүйд шүүхийн шийтгэх тогтоолыг зөрчсөн, эсхүл мэдүүлэг авах боломжгүй байсан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх албан тушаалтныг чөлөөлдөггүй. Шүүгчийн буруутай үйл ажиллагаа болон эрх мэдлээ урвуулан ашигласан бол тухайн иргэний гомдол, нотлох баримтыг үндэслэн Хууль зүйн яамнаас томилогдож ирсэн Тусгай төлөөлөгч хянаад Ерөнхий прокурорт танилцуулж, тусгай чиглэл авдаг. Энэ нь Үндсэн хууль болон Конгрессын аливаа хууль, тогтоомж нь Колумбийн дүүргийн дагаж мөрдөх журам гэж үздэг байна.

АНУ-н хууль зүйн яам жил бүр иргэдээс хууль сахиулах байгууллагуудын талаар статистик судалгаа авдаг бөгөөд тэрхүү судалгаанд үндэслэн хууль сахиулах байгууллагуудад чиглэл, зөвлөмж өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байна.

2024 оны хамгийн сүүлийн судалгаанд хууль сахиулах байгууллагуудын дундаас цагдаагийн газар жил бүр хүч хэтрүүлэн ашигласан, цагдаагийн харгислалтай холбоотой олон нийтийн зүгээс олон тооны гомдол, мэдээлэл хүлээн авсан байна.

[12] Б. Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан “Прокурорын хяналт”, 2009, УБ

Эдгээр гомдлын 80 орчим хувь нь цагдаагийн албан хаагчид иргэний эрхийг зөрчсөн, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, хууль бусаар баривчлах, үймээн самуунтай тэмцэх нэрийдлээр эрүүдэн шүүх, ялгаварлан гадуурхалт, бэлгийн хүчирхийлэл зэрэгтэй холбоотой байна.

АНУ-ын Хууль зүйн яамнаас 1999 онд батлагдсан Холбооны улсын эрх зүйн актуудын код (Code of Federal regulations)-ын 28 дугаар хэсгийн VI бүлгийн 600 (28 CFR Part 600)[13]-д Тусгай төлөөлөгчид холбогдох дараах асуудлуудыг зохицуулжээ. Үүнд:

600.1 Тусгай төлөөлөгчийг томилох үндэслэл;
600.2 Ерөнхий прокуророос авах арга хэмжээний хувилбарууд;
600.3 Тусгай төлөөлөгчид тавигдах шаардлага;
600.4 Тусгай төлөөлөгчийн эрх мэдлийн хүрээ;
600.5 Тусгай төлөөлөгчид туслах ажилтан, албан хаагчид;
600.6 Тусгай төлөөлөгчийн бүрэн эрх;
600.7 Тусгай төлөөлөгчийн үүрэг, хариуцлага;
600.8 Тусгай төлөөлөгчийн мэдэгдэл болон мөрдлөгийн тайлан;
600.9 Ерөнхий прокурорын мэдэгдэл болон тайлан;
600.1 Тусгай төлөөлөгчийг томилох үндэслэл.

Ерөнхий прокурор, эсхүл ерөнхий прокурор татгалзсанаар үүрэг гүйцэтгэгч томилогдсон тохиолдолд тодорхой хүн, эсхүл хэрэг дээр мөрдлөг явуулах шаардлагатай гэж үзвэл Ерөнхий прокурорын үүрэг гүйцэтгэгч дараах тохиолдолд Тусгай төлөөлөгчийг томилох эрхтэй.

(а) Ерөнхий прокурорын ажлын алба болон Хууль зүйн яамны шүүн таслах хэлтсийн ажилтнууд тухайн хүн, эсхүл тухайн асуудлыг мөрдөх, яллах ажиллагааг явуулахад ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй нөхцөл байдлууд үүсч болзошгүй тохиолдолд;

(б) Иргэд, олон нийтийн зүгээс тухайн хэргийг мөрдөн шалгахдаа тусгай төлөөлөгч томилохыг шаардсан тохиолдолд.

600.2 Тусгай төлөөлөгчид тавигдах шаардлага

(а) Тусгай төлөөлөгчөөр томилогдох этгээд нь хуульч мэргэжилтэй, аливаа нөлөөнд автахгүй, аль нэг талыг баримтлан шийдвэр гаргахгүй байх боломжтой, мэргэжлийн туршлага дээрээ тулгуурлан мөрдлөгийг шуурхай, нарийвчилсан байдлаар явуулах чадвартай байх ба АНУ-ын Эрүүгийн хууль болон Хууль зүйн яамны бодлогыг мөрдөн шалгах болон яллах үйл ажиллагаандаа баримталж шийдвэр гаргана.

[13] https://www.law.cornell.edu/cfr/text/28/part-600

АНУ-ын Засгийн газарт ажилладаг этгээдийг тусгай төлөөлөгчөөр томилохыг хориглоно.

(б) Тусгай төлөөлөгчөөр томилох этгээдийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийж, ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчил бий эсэхийг нарийвчлан шалгасны үндсэн дээр “итгэмжлэгдсэн ажилтан”-аар томилно.

600.4 Тусгай төлөөлөгчийн эрх мэдлийн хүрээ

Олгогдсон эрх: Ерөнхий прокурорын олгосон эрхийн хүрээнд тусгай төлөөлөгч нь үүргээ гүйцэтгэнэ. Тусгай төлөөлөгч нь ажил үүргээ гүйцэтгэхдээ тодорхой баримт нотолгоо бүхий мэдээллээр хангагдах ёстой. Тусгай төлөөлөгч нь худал мэдүүлэг өгөх, үнэн мөнийг гуйвуулах, баримт нотолгоог устгах, гэрчийг айлган сүрдүүлэх зэрэг гэмт хэргүүдийг мөрдөх, ял оноох эрхтэй.

Нэмэлт эрх: Хэргийг мөрдөх явцад тус хэргийг илрүүлэхтэй холбоотой нэмэлт ажиллагаа шаардагдсан, эсхүл шинээр мөрдлөг хийх шаардлагатай болсон тохиолдолд Ерөнхий прокурортой зөвлөлдөн шийдвэрлэнэ. Ерөнхий прокурор тусгай төлөөлөгчийн эрхийг нэмэгдүүлэх, эсхүл өөр байгууллага болон ажилтанд үүрэг өгөх зэргээр асуудлыг шийдвэрлэж болно.

Иргэний болон захиргааны эрх: Мөрдөх явцад буруутан этгээдэд захиргааны болон иргэний (эрүүгийн бус) шийтгэл ногдуулах боломжтой гэж үзвэл Ерөнхий прокурортой зөвлөлдөж шийдвэрлэнэ.

600.5 Тусгай төлөөлөгчид туслах ажилтан, албан хаагчид

Тусгай төлөөлөгч нь шаардлагатай тохиолдолд Хууль зүйн яамны ажилтнуудаас тусламж дэмжлэг авч болно. Тус яамнаас хэргийг мөрдөхөд тохиромжтой албан хаагчдын мэдээллийг тусгай төлөөлөгчид гарган өгснөөр тохирох ажилтнуудыг сонгон, тэдгээрийг удирдан, үүрэг даалгавар өгч ажиллуулна. Шаардлагатай бол тус ажилтнуудыг яамнаас гадуур ажиллуулах боломжтой.

600.6 Тусгай төлөөлөгчийн бүрэн эрх

Тусгай төлөөлөгч нь өөрт олгосон эрхийн хүрээнд, АНУ-ын аль ч прокурорын адил мөрдлөг явуулах, ял оноох эрхтэй. Тусгай төлөөлөгч нь тухайн хэргийн мөрдөлт аль шатанд явж байгаа зэрэг хэрэгт холбоотой мэдээллийг Ерөнхий прокурор болон Хууль зүйн яамны ажилтнуудад мэдээлэх эсэхээ өөрөө шийднэ.

600.7 Тусгай төлөөлөгчийн үүрэг хариуцлага

(а) Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журам, бодлогыг баримталж ажиллана. Хэрэв тусгай төлөөлөгч өөрийн гаргасан шийдвэртээ итгэлтэй байгаа боловч тэр нь Хууль зүйн яамны дүрэм, журамд нийцэхгүй тохиолдолд нэн даруй Ерөнхий прокурортой зөвлөлдөх шаардлагатай.

(б) Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны хэн нэгэн албан тушаалтны өдөр тутмын хараа хяналтан дор ажиллахгүй. Гэвч Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийн хийсэн аливаа мөрдлөг болон буруутан этгээдэд ногдуулсан ялын талаар тайлбар авч болно. Хэрэв тусгай төлөөлөгчийн авсан арга хэмжээ нь Хууль зүйн яамнаас авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаатай нийцэхгүй болон шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд цаашид үргэлжлүүлэхийг хориглоно. Тус шалгалтыг явуулж, шийдвэр гаргахдаа тусгай төлөөлөгчийн цаашдын байр суурь, төлөвлөгөөг сайтар анхаарч авч үзнэ. Хэрэв Ерөнхий прокурор тусгай төлөөлөгчийн хэрэгжүүлж буй болон цаашид төлөвлөж буй үйл ажиллагаа нь шаардлагагүй болон тохиромжгүй гэж үзвэл 600.9(а)(3)-т зааснаар Конгресст мэдэгдэнэ.

(в) Тусгай төлөөлөгч болон ажлын албаны гишүүд нь Хууль зүйн яамны ажилтан, албан хаагчдын нэг адил ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн буруутай үйлдэл хийсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулна. Ерөнхий прокурорын зөвшөөрлөөр Хууль зүйн яамны тодорхой хэлтэс, алба нь тухайн асуудлыг судалж, арга хэмжээ авна.

(г) Зөвхөн Ерөнхий прокурор л тусгай төлөөлөгчид шийтгэл ногдуулах болон үүрэгт ажлаас нь чөлөөлөх эрхтэй. Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийг албан тушаалаа ашиглан гэмт хэрэг үйлдсэн, ажил үүргээ гүйцэтгээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй, Хууль зүйн яамны дүрэм, журмыг зөрчсөн зэрэг тохиолдлуудад үүрэгт ажлаас нь чөлөөлнө. Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийг ямар шалтгааны улмаас ажлаас чөлөөлж буй тухайгаа өөрт нь бичгээр мэдэгдэнэ.

600.8 Тусгай төлөөлөгчийн ажлын тайлан

(а) Төсөв (1) Хууль зүйн яамнаас тусгай төлөөлөгчийг үүрэгт ажлаа гүйцэтгэх бүхий л нөөц бололцоогоор хангана. Томилогдсоноосоо хойш 60 хоногийн дотор тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны Зохион байгуулалтын хэлтэстэй хамтран төсвийн санал боловсруулж, Ерөнхий прокурорт хянуулахаар өгнө. Тухайн санал дээр үндэслэн Ерөнхий прокурор нь тусгай төлөөлөгчийн үйл ажиллагааны төсвийг боловсруулна. Төсөвт мэргэшил, дадлага бүхий албан хаагчийг авч ажиллуулах зардлыг багтаасан байна.

(2) Санхүүгийн жил эхлэхээс 90 хоногийн өмнө тусгай төлөөлөгч нь Ерөнхий прокурорт хэргийн мөрдлөгийн үйл явцыг мэдээлж, дараа жилийн төсвийн саналаа танилцуулна. Ерөнхий прокурор нь мөрдөх үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай гэж үзвэл ирэх жилийн төсөвт тусгана.

(б) Онц чухал үйл явдлуудын талаар мэдээлэх

Тусгай төлөөлөгч нь Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу мөрдлөгийн явцад бий болсон гэнэтийн үйл явдлын талаар Ерөнхий прокурорт мэдээлэх шаардлагатай.

(в) Гэмт хэргийг хаах

Тусгай төлөөлөгч нь мөрдөн шалгах үйл явц дууссаны дараа гэмт этгээдэд ногдуулсан ял, эсхүл гэм буруугүйг нотолсон нотолгоог Ерөнхий прокурорт танилцуулна.

600.9 Ерөнхий прокурорын тайлан

(а) Ерөнхий прокурор нь доорх нөхцөлүүдэд Конгрессын хоёр танхимын Хууль зүйн хорооны дарга нарт мэдэгдэл хийнэ. Үүнд:

(1) Тусгай төлөөлөгчийг томилоход;
(2) Тусгай төлөөлөгчийг чөлөөлөхөд;
(3) Тусгай төлөөлөгчийн авсан арга хэмжээ нь Хууль зүйн яамны дүрэм, журмыг зөрчсөн, тухайн арга хэмжээг авах шаардлагагүй байсан, эсхүл тохиромжгүй арга хэмжээ авсан гэж үзэн мөрдлөгийг үргэлжлүүлэхийг хориглосон тохиолдолд.

(б) Тусгай төлөөлөгчийн мөрдсөн болон ял ногдуулсан аливаа хэргийг Хууль зүйн яамны дүрэм, журамд заасны дагуу Ерөнхий прокурор олон нийтэд мэдээлэх эсэхийг шийдвэрлэнэ.

2.2. БҮГД НАЙРАМДАХ АРМЕНИ УЛС

Бүгд Найрамдах Армени Улс нь Баруун Азийн Арменийн өндөрлөгт орших далайд гарцгүй орон юм. Баруун талаараа Турк Улс, хойд талаараа Гүрж Улс, зүүн талаараа Азербайжан Улс, урд талаараа Иран Улс, Азербайжан Улстай тус тус хиллэдэг. Армени Улсын нийслэл нь Ереван хот. 2022 оны байдлаар нийт хүн ам 3 сая бөгөөд тэдний 95% нь армян үндэстнүүд бүрдүүлдэг. 29,743 км нутаг дэвсгэртэй, нэг хүнд ногдох ДНБ нь 19,489 ам.доллар, мөнгөний нэгж нь Драм (֏) (AMD), албан ёсны хэл нь армян хэлтэй. Нэгдмэл парламентын бүгд найрамдах улс.

Бүгд Найрамдах Армени Улсын Мөрдөн шалгах тусгай алба[14] нь " Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль" (*Закон о специальной следственной службе)*-аар тогтоосон төрийн албаны тусгай төрөл бөгөөд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан хүний болон иргэний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийг дээдлэн хүндэтгэх, хүнлэг энэрэнгүй, ил тод байх зарчмыг баримтлан ажилладаг.

Мөрдөн шалгах тусгай албанд харьяалагдах байгууллагууд*:*

- Үндэсний аюулгүй байдлын газар;
- Цагдаагийн байгууллага;
- Татварын алба;
- Гаалийн байгууллага;
- Шүүхийн шийдвэрийг албадан хэрэгжүүлэх зэрэг байгууллагууд байх бөгөөд хараат бус байдлаар бүрэн эрхээ хэрэгжүүлдэг бие даасан статустай байгууллагууд байна.

Мөрдөн шалгах тусгай албаны үйл ажиллагааны зорилго нь: гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тодорхойлох, эрүүгийн хариуцлагаас зайлсхийсэн болон сураггүй алга болсон этгээдийг эрэн сурвалжлах, тогтоох, гэрч, цогцос, гэмт хэргийн ул мөр, эд зүйл, эд мөрийн баримт, материалыг илрүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай мэдээллийг олж авах, хууль бусаар гааль болон хил нэвтрүүлэхийг илрүүлэх, таслах зогсоох, татварын хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх, ил болгох, хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, урьдчилан сэргийлэх, төрийн тусгай хамгаалалтад буй ажилтны аюулгүй байдлыг арилгах, төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэлд нэвтрэх зөвшөөрөх, мөрдөн байцаалтын үйл ажиллагаа явуулж буй ажилтнууд тэдний гэр бүлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор мэдээлэл цуглуулах, мөрдөн байцаалтын материалтай танилцах, гадаадын иргэн болон харьяалалгүй этгээдэд иргэншил, улс төрийн орогнол, оршин суух статус олгох тухай дүгнэлт гаргах, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл цуглуулахад оршино.

Бүтцийн хувьд Мөрдөн шалгах тусгай алба нь дараах хэлтсүүдээс бүрдэнэ[15]. Үүнд:

1. Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг, албан тушаалтны гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Corruption, Organized and Official Crimes*);

[14] Мөрдөн байцаах тусгай албаны ажлын албаны журам, 3 дугаар бүлэг 13 дугаар зүйл http://www.ccc.am/ru/1428578692
[15] http://www.ccc.am/en/1428926241

2. Эрүүдэн шүүх болон хүний эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Tortures and Crimes against Person*);
3. Нийтлэг шинжтэй гэмт хэргийг мөрдөн шалгах хэлтэс (*Department of Investigation of Crimes of General Character*) зэрэг болно.

Мөрдөн шалгах тусгай алба нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдах албан тушаалтан болон төрийн тусгай албаны ажилтан албан тушаалаа урвуулан ашиглах, эсхүл биеэр үйлдсэн гэмт хэрэг, мөн сонгуулийн үйл явцтай холбоотой эрүүгийн гэмт хэргийг урьдчилан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулна.

Дээрх хуульд зааснаар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын удирдах ажилтанд дараах албан тушаалтныг хамруулна[16]. Үүнд:

- Улсын Ерөнхийлөгч;
- Ерөнхий сайд,
- Шадар сайд;
- Парламентын гишүүд;
- Үндсэн хуулийн шүүхийн тэргүүн болон гишүүд;
- Шүүхийн тэргүүн болон шүүгчид;
- Улсын Ерөнхийлөгчийн ажлын албаны дарга;
- Үндэсний Хурлын (парламент) ажлын албаны дарга;
- Засгийн газрын ажлын албаны дарга;
- Засгийн газрын сайдууд, дэд сайдууд;
- Засгийн газрын харьяа агентлагууд болон төрийн захиргааны төв байгууллагын дарга, орлогчид;
- Мужийн захирагч, тэдгээрийн орлогчид;
- Ереван хотын захирагч, түүний орлогчид;
- Төрийн Хянан Шалгах Палатын зөвлөлийн дарга, гишүүд;
- Төв банкны дарга, зөвлөлийн гишүүд;
- Зохицуулах хороодын дарга, гишүүд;
- Сонгуулийн хорооны дарга, гишүүд;
- Үндэсний Статистикийн хорооны дарга, орлогч дарга зэрэг болно.

[16] Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль, 1 дүгээр бүлэг, 4.2 дугаар зүйл http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus

Төрийн тусгай албанд үүрэг гүйцэтгэгчид дараах албан хаагчид орно[17]. Үүнд:

- Прокурор;
- Батлан хамгаалах салбар дахь төрөөс бүрэн эрх олгосон байгууллагад ажилладаг мөрдөгчид (*Следователи государственного уполномоченного органа в области обороны*);
- Цагдаагийн албан хаагч (*цэргийн цагдаа орохгүй*);
- Үндэсний аюулгүй байдлын албан хаагч (*хилийн цэрэг, зэвсэгт хүчин орохгүй*);
- Татварын байгууллагын албан хаагч;
- Гаалийн байгууллагын албан хаагч;
- Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх байгууллагын албан хаагч;
- Эрүүгийн хэргийн гүйцэтгэх алба;
- Авран хамгаалах албаны албан хаагч зэрэг тусгай албадын эрх бүхий албан тушаалтнуудыг хэлнэ.

Мөрдөгдөж буй хууль тогтоомжууд[18]**:**

- Үндсэн хууль;
- Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэхлэх тухай хууль;
- Гаалийн тухай хууль;
- Прокурорын байгууллагын тухай хууль;
- Үндэсний аюулгүй байдлын тухай хууль;
- Цагдаагийн тухай хууль;
- Эрүүгийн гүйцэтгэх албаны тухай хууль;
- Татварын албаны тухай хууль;
- Олон Улсын гэрээ хэлэлцээр;
- холбогдох бусад хууль тогтоомжуудаар зохицуулагдана.

Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль:

Уг албаны үйл ажиллагааг 2007 онд батлагдсан Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль (*Закон о специальной следственной службе)*-иар зохицуулдаг бөгөөд 2009 онд 2 удаа хуульд өөрчлөлт оруулсан байна. Тус улсын Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль нь харьцангуй нарийвчилсан зохицуулалттай хууль юм.

[17] Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль, 1 дүгээр бүлэг, 4.3 дугаар зүйл http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3124&lang=rus

[18] http://www.parliament.am/legislation.php?sel=alpha&ltype=3&lang=eng

“Мөрдөн шалгах тусгай албаны тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Тусгай мөрдөн байцаах албаны даргыг тус улсын Ерөнхий прокурорын санал болгосноор Бүгд Найрамдах Армени Улсын Ерөнхийлөгч уг албан тушаалд томилдог байна. Бүгд Найрамдах Армени Улсын Ерөнхийлөгч энэ хуулийн 12 зүйлд заасан (мөрдөн байцаах тусгай ажилтныг албан тушаалаас чөлөөлөх тухай) үндэслэлээр тусгай мөрдөн байцаах албаны даргыг албан тушаалаас чөлөөлнө.

Мөрдөн байцаах тусгай албаны бусад албан тушаалыг тусгай албаны дарга томилж, чөлөөлнө.

Энэ хуулиар Мөрдөн шалгах тусгай алба байгуулах болон үйл ажиллагаа явуулах нөхцөл, журам, мөн албан хаагчдын ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой харилцаа, албан тушаалын ангилал, зэрэглэл, эрх, үүрэг хариуцлага, эрх зүйн, болон нийгмийн баталгаа, албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой бусад харилцааг зохицуулна.

Дээрх хуулийн 3 дугаар бүлэгт зааснаар Мөрдөн шалгах тусгай албаны дарга нь тусгай мөрдөн шалгах албаны ажилтны үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж, удирдан зохион байгуулна. Мөрдөн шалгах тусгай албаны ажилтны ажил үүргээ биелүүлэхэд нь саад учруулах, хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй байх, түүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд халдах, эсхүл бусдад халдах халдлага нь хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. Мөрдөн шалгах тусгай албаны ажилтны эсрэг эрүүгийн хэрэг үүсгэн шалгах эрүүгийн хэргийн харьяаллыг Армени Улсын Ерөнхий прокурор тогтооно.

Мөрдөн шалгах тусгай албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу Тусгай мөрдөн байцаах албаны даргыг тус улсын Ерөнхий прокурорын санал болгосноор Бүгд Найрамдах Армени Улсын Ерөнхийлөгч уг албан тушаалд томилдог байна. Бүгд Найрамдах Армени Улсын Ерөнхийлөгч энэ хуулийн 12 зүйлд заасан (мөрдөн байцаах тусгай ажилтныг албан тушаалаас чөлөөлөх тухай) үндэслэлээр тусгай мөрдөн байцаах албаны даргыг албан тушаалаас чөлөөлж чөлөөлнө. Мөрдөн байцаах тусгай албаны бусад албан тушаалыг тусгай албаны дарга томилж, чөлөөлнө.

2.3. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ нь Ерөнхийлөгчийн засаглалтай учраас төрийн төв байгууллагуудын удирдлагыг ихэвчлэн Ерөнхийлөгч нь томилдог онцлогтой. Өмнөд Солонгос Улсын Дээд прокурор (Prosecutor General)-ыг томилох үйл явц нь БНСУ-ын Үндсэн хуулиар зохицуулагдсан, хэд хэдэн үе шаттайгаар хэрэгждэг. Үүнд[19]:

- Нэр дэвшүүлэх: Дээд прокурорт нэр дэвшигчийг тодруулах үйл явцыг Хууль зүйн сайд удирдан зохион байгуулна. Хууль зүйн сайд нь дээд прокурорт нэр дэвшигчийг сонгон шалгаруулах үүрэгтэй бөгөөд энэ үйл явцад прокурорууд болон хууль зүйн салбарын мэргэжилтнүүдийн саналыг авдаг.
- Үндэсний Ассамблейн сонсгол: Ерөнхийлөгчийн санал болгосон нэр дэвшигчийг Үндэсний Ассамблейн сонсголын хуралдаанд оролцуулж, хэлэлцүүлдэг авдаг. Энэ үеэр нэр дэвшигчийн мэргэшил, ёс зүйн байдал болон туршлагыг нарийвчлан хэлэлцдэг.
- Ерөнхийлөгч томилох: Хууль зүйн сайдын санал болгосон нэр дэвшигчийг БНСУ-ын Ерөнхийлөгч сонгон, Үндэсний Ассамблейгаар хэлэлцүүлсний дараа албан ёсоор томилдог.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 4-р зүйлд зааснаар прокурор нь дараах үндсэн чиг үүрэгтэй[20]:

1. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд дараах гэмт хэрэгт Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно.
    (а) Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон авлигын гэмт хэрэг, эдийн засгийн гэмт хэрэг, төрийн албан тушаалтны гэмт хэрэг, сонгуулийн гэмт хэрэг, батлан хамгаалах салбарын гэмт хэрэг, гамшиг сүйрлийн үеийн гэмт хэрэг;
    (б) Цагдаагийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэрэг;
    (в) (а), (б)-д заасан гэмт хэрэгтэй шууд холбоотой гэмт хэрэг, шүүхийн цагдаагийн ажилтны шилжүүлсэн гэмт хэрэг;
2. Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд цагдаагийн тусгай алба хаагчдыг удирдан чиглүүлж, хяналт тавих;
3. Хууль, журмыг зохих ёсоор хэрэглэх асуудлаар шүүхэд хүсэлт гаргах;
4.Шүүхийн шийдвэрийн биелэлтийг удирдан чиглүүлэх, хяналт тавих;
5.Шүүх хуралдаанд төрийг төлөөлөн оролцох;
6 Хууль, журмын дагуу прокурорын бүрэн эрхэд хамаарах бусад асуудал.

[19] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1
[20] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55253&lang=ENG

БНСУ-д шүүгч, прокурор, мөрдөгч зэрэг тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийн мөрдөн шалгах эрх бүхий 2 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. тэдгээр нь:

1. Дээд прокурорын газрын харьяа Мөрдөн байцаах алба
2. Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах алба (Corruption Investigation Office for High-ranking Officials, ӨАТАХМША)

1. Дээд прокурорын газрын харьяа Мөрдөн байцаах алба

БНСУ нь Авлигатай тэмцэх бие даасан байгууллагатай боловч Улсын Дээд прокурорын газрын бүтцэд авлигын эсрэг болон зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий тусгай алба - ***Прокурорын тусгай мөрдөн байцаах алба*** *(Special Investigation Agency*) ажилладаг.[21] Тус алба Ерөнхий прокурорт шууд харьяалагдах, босоо удирдлагын тогтолцоотой бөгөөд Прокурорын мөрдөн байцаах ажиллагааг явуулна.

Тусгай мөрдөн байцаах албаны нэгж нь дүүргийн прокурорын газарт ахлах прокурор, прокурор, тусгай төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй ажилладаг. Тэд дүүргийн прокуророос шилжүүлсэн хэрэг болон хууль тогтоомжоор өөрт харьяалуулсан гэмт хэргүүдэд тусгай мөрдөн шалгах, мөрдөн байцаах ажиллагаа явуулна.

Прокурорын мөрдөн байцаах алба дараах хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

1. Олны анхааралд орсон авлигын томоохон хэрэг: Тус алба нь засгийн газрын сайд, Үндэсний ассамблейн гишүүд, орон нутгийн засаг захиргааны тэргүүн зэрэг өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг шалгах үүрэгтэй. Эдгээр хэргүүд нь ихэвчлэн улс төрийн болон нийгмийн ихээхэн ач холбогдол, үр дагавартай байдаг. Тухайлбал: Улсын эдийн засаг, аюулгүй байдал, өрсөлдөх чадвар, ил тод байдалд хохирол учруулахуйц (авлига, зуучлах, зуучилсны төлөө төлбөр авах, хувьдаа ашиглах, завших, итгэл эвдэх) гэмт хэргүүд байдаг;
2.Үндэстэн дамнасан корпорацын болон санхүүгийн гэмт хэрэг: Тэд залилан мэхлэх, хөрөнгө шамшигдуулах, дотоод мэдээлэл солилцох зэрэг томоохон хэмжээний санхүүгийн гэмт хэрэг, ялангуяа томоохон компани, төрийн байгууллагуудтай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгадаг.
3.Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах ба нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг: Тус алба тагнуул хийх, нууц мэдээлэл, задруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангах батлан хамгаалах үйл ажиллагаа дахь

[21] https://www.spo.go.kr/site/eng/01/1010301000000020181206O5.jsp

авлигын гэх мэт улс орны үндэсний аюулгүй байдалд нэн чухал гэж үзсэн хэргүүдийг авч үздэг.

4.Үндэсний баялгийг гадагш гаргахтай холбоотой гэмт хэрэг: Улсын томоохон технологийг эзэмшиж, ашиглаж буй байгууллага, компанийн сүүлийн үеийн технологийг гадагш гаргахтай холбоотой гэмт хэргийг шуурхай илрүүлэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах;

5. Санхүүгийн болон үнэт цаастай холбоотой гэмт хэрэг: олон тооны хохирогчтой санхүүгийн гэмт хэрэг, их хэмжээний хувьцааны үнийг хуурамчаар өсгөх бууруулах замаар үйлдсэн зохион байгуулалттай гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.

Прокурорын тусгай мөрдөн байцаах алба нь үйл ажиллагаандаа Прокурорын тухай хууль болон Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөнө. Прокурорын байгууллагын тухай хуульд зааснаар шинээр хэлтэс, алба байгуулах, түүний эрх хэмжээг тогтоохтой холбоотой асуудлыг Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

БНСУ-ын хувьд Прокурорын байгууллага нь Хууль зүйн яам, Цагдаагийн байгууллага нь Дотоод хэргийн яамандаа харьяалагддаг.

2. Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах алба (ӨАТАХМША)[22]

Энэхүү алба нь 2021 онд байгуулагдсан, авлигын хэргийг мөрдөн шалгах, өндөр албан тушаалтнуудын гэмт хэрэгтэй тэмцэх зорилготой бие даасан, хараат бус, тусгай байгууллага юм[23]. Албаны дарга (Director General)-ыг Ерөнхийлөгч шууд томилдог. Гэвч даргыг томилох үйл явц нь хэд хэдэн үе шаттайгаар үргэлжилдэг.

Эхний ээлжид даргад нэр дэвшигчийг тодруулах томилолтын хороо байгуулагддаг. Энэ хороо нь 7 гишүүнээс бүрдэх ба Хууль зүйн сайд, Шүүхийн удирдлагын газрын сайд, Өмнөд Солонгосын Хуульчдын холбооны ерөнхийлөгч болон эрх баригч хоёр нам, сөрөг хүчний хоёр намаас томилогдсон гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Хороо сонгон шалгаруулалтын зохион байгуулж тус албаны даргад нэр дэвшүүлж, хамгийн өндөр оноо авсан хоёр хүний нэрийг БНСУ-ын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлдэг. Ерөнхийлөгч тэдний аль нэгийг сонгож томилдог байна.

[22] https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53133&lang=ENG
[23] https://cio.go.kr/eng/content/243

ӨАТАХМША нь даргаас гадна дараах албан тушаалтнуудаас бүрдэнэ[24]. Үүнд:

- Дэд дарга: Даргыг орлон ажилладаг бөгөөд ӨАТАХМША-ны ажлын дотоод зохицуулалт, уялдаа холбоог хариуцдаг;
- Прокурорууд: ӨАТАХМША-д 25 хүртэл прокурор ажиллах ба эдгээр прокурорууд нь хуулийн салбарт 7-аас дээш жил ажилласан туршлагатай байх ёстой;
- Мөрдөн байцаагчид: ӨАТАХМША-д 40 хүртэл мөрдөн байцаагч ажилладаг бөгөөд тэдгээр нь хэрэг мөрдөн шалгах үүрэгтэй.

Эрх хэмжээ

ӨАТАХМША нь өндөр албан тушаалтнуудын гэмт хэргийг мөрдөн шалгах, мөрдөн байцаах, болон гэмт хэргийг прокурорын байгууллагын хяналтаас тусдаа бие даан мөрдөх эрхтэй. Үүнд:

- Бүх төрлийн авлигын хэргийг мөрдөн шалгах;
- Шүүх, хууль сахиулах байгууллагын албан хаагчдын гэмт хэргийг шалгах.

ӨАТАХМША нь бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч албан тушаалтныг мөрдөн шалгах бие даасан эрхтэй бөгөөд үүнд дараах өндөр албан тушаалтнууд багтана. Тухайлбал:[25]

- Ерөнхийлөгч болон түүний гэр бүлийн гишүүд;
- Үндэсний Ассамблейн гишүүд;
- Дээд шүүхийн болон Үндсэн хуулийн шүүхийн шүүгч, шүүгчид;
- Ерөнхий прокурор, прокурорууд;
- Засгийн газрын сайд, дэд сайд нар;
- Цагдаагийн дээд албан тушаалтнууд;
- Цэргийн болон цагдаагийн дээд түвшний удирдлагууд.

Мөрдөн шалгах хэргийн харьяалал

ӨАТАХМША нь төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой дараах төрлийн хэргүүдийг мөрдөн шалгадаг:[26]

- Авлигын хэрэг: Төрийн албан тушаалтан авлига авсан, эсвэл авлига өгөх хэрэгт оролцсон тохиолдлуудыг мөрдөн шалгана;
- Эрх мэдлээ урвуулан ашиглах гэмт хэрэг: Төрийн албан тушаалтан албан тушаалаа ашиглан өөрийн болон бусдын ашиг сонирхлын төлөө хууль зөрчсөн тохиолдлууд;

[24] https://cio.go.kr/eng/content/244
[25] https://cio.go.kr/eng/content/246
[26] https://cio.go.kr/eng/content/247

- Хууль бус санхүүгийн гүйлгээ, хандив: Сонгууль болон улс төрийн бусад үйл ажиллагаатай холбоотой санхүүгийн зөрчлүүдийг шалгах;
- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын гэмт хэрэг: Прокурор, мөрдөгч, шүүгч зэрэг хууль сахиулагчдын гэмт хэргийг бие даан мөрдөн шалгах.

ӨАТАХМША нь бие даасан мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд авлига болон өндөр албан тушаалтнуудын хэргийг шууд хариуцан шалгадаг. Мөрдөн шалгах явцад ӨАТАХМША нь цагдаагийн байгууллага, Дээд прокурорын газар болон бусад хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах боломжтой боловч, тэдгээр байгууллагаас хамааралгүй бие даасан шийдвэр гаргах эрхтэй.

Энэхүү бүтэц, зохион байгуулалт нь БНСУ-ын хууль сахиулах тогтолцоонд прокурорын байгууллагын хэт төвлөрсөн эрх мэдлийг саармагжуулах, шинэ төвийг сахисан хяналтын байгууллагыг бий болгож, авлигын эсрэг хяналтыг сайжруулах зорилготой байна.

АШИГЛАСАН ЭХ МАТЕРИАЛ

Монгол Улс

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694
- ЦЕГ-ийн Мөрдөн байцаах алба: https://police.gov.mn/o/29
- Авлигатай тэмцэх газар: https://iaac.mn/erhem-zorilgo-undsen-zarchim-tuuhen-zarchim
- Мөрдөх албаны талаарх харьцуулсан судалгаа, ННФ, 2021:
- Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги: Гэмт хэргийн бүтэц, Т.Золбоо, 2018 он
- СТ-19/202 “хууль, хүчний байгууллагын албан хаагчид болон төрийн өндөр албан тушаалтнуудад холбогдох хэргийг мөрдөн шалгах хараат бус байгууллагын талаарх харьцуулсан судалгаа: монгол улс болон гадаадын зарим орны туршлага” ПССХ, 2019
- https://cdn.greensoft.mn/uploads/users/3172/files/ATG%20tailan-24_01_03.pdf https://police.gov.mn/resource/information/File/2024/01/09/n5s1moym427bp5fn/Сайт%20сэжигтэн.pdf

АНУ

- Civil Rights Act Section 1983 – Deprivation of Rights
- S. Constitution – Fourth Amendment

- Rightshttps://www.law.cornell.edu/rio/citation/Pub._L._96-170
- https://www.justice.gov/crt/law-enforcement-misconduct
- https://www.law.cornell.edu/uscode/text/18/242
- “Прокурорын хяналт”, Б. Цэрэнбалтав, Б. Амарбаясгалан, 2009,УБ
- https://www.law.cornell.edu/cfr/text/28/part-600

Армени Улс

- Армени Улсын Парламентын хуулийн веб сайт http://www.parliament.am/legislation.php?lang=rus&sel=alpha&ltype=3
- Үндсэн хууль; http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=1&lang=rus
- Прокурорын байгууллагын тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=5947&lang=rus
- Гадаадын тагнуулын алба болон үйл ажиллагааны тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=8554&lang=rus
- Иргэний хууль http://www.parliament.am/law_docs/050598HO239rus.html?lang=rus#G1
- Мөрдөн байцаах тусгай албаны тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=4951&lang=rus
- Татварын албаны тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=1323&lang=rus
- Татварын тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=5600&lang=rus
- Төрийн тусгай хамгаалалтад буй этгээдийн аюулгүй байдлын хангах тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=5600&lang=rus
- Мөрдөн шалгах тусгай ажиллагааны тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=3093&lang=rus
- Үндэсний аюулгүй байдлын байгууллагын тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=1278&lang=rus
- Цагдаагийн тухай хууль http://www.parliament.am/legislation.php?sel=show&ID=1271&lang=rus

БНСУ

- БНСУ-ын Үндсэн хууль: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1
- Прокурорын байгууллагын тухай хууль: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=55253&lang=ENG

- Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах албаны үйл ажиллагаа, байгуулалтын тухай хууль: https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=53133&lang=ENG
- БНСУ-ын Дээд прокурорын газрын албан ёсны веб сайт: https://www.spo.go.kr/site/eng/main.do
- Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах албаны албан ёсны веб сайт: https://cio.go.kr/eng/
- https://www.unafei.or.jp/publications/pdf/RS_No53/No53_13VE_Soo.pdf